

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1995 оны 06 дугаар  
Сарын 10 –ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Үнэт цааст тооцох тухай

Үнэт цаасны тухай хуулийн 3 дугаар зүйл, хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдсан компаниудын хувьцааг үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн бүртгэлд авсныг үндэслэн Монгол Улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдсан компанийн хувьцааг үнэт цааст тооцсугай.

2. Хувьчлагдсанаас хойш Монголын Хөрөнгийн биржид үнэт цаасны гүйлгээний талаарх мэдээ, тайлангаа тогтоосон хугацаанд ирүүлээгүй хавсралтад дурдсан хувьцаат компаниуд 1994 оны эцсийнхээс эхлэн тайлан мэдээгээ Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид ирүүлж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг эдгээр компаниудын удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН